



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

1617 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 55

Арвайхээр


**Аймгийн хөтөлбөр, төлөвлөгөө
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 -ын "ж", 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Олон нийтийн оролцоот сургууль" аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Сургуулийн орчин дахь орон нутгийн иргэд, эцэг эхчүүдийн бүтээлч, хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоог сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж, ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн Их Хурлын Сургуулиар
2017 оны 07 сарын 07-ний өдөр
55 дугаар тогтоолын захирамжаар баталсан

“ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ СУРГУУЛЬ” ХӨТӨЛБӨР **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улсын “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 20.2.2 дахь заалт “Сургууль хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад багш, сурагч, эцэг эх, олон нийтийн оролцоо, түншлэлийг ханган ажиллах”, 20.2.4 дэх заалт “Сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг сургуулийн зөвлөл, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотойгоор төлөвлөх, сургалтын орчныг бэхжүүлэх, төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, мэдээлэх; 20.2.11 дэх заалт “Шийдвэр гаргахад багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл, багш, суралцагч, эцэг эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулийн үйл ажиллагаа, сургалтын явц, үр дүнгийн талаар нээлттэй мэдээлэх” гэж тусгасан төдийгүй Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын баримт бичигт “Боловсролын үйл хэргийг удирдахад төрийн болон нутгийн захиргааны, иргэний нийгмийн байгууллага, гэр бүл, нийгмийн бүх салбарын оролцоонд суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлнэ”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “сургуулийг хүн хөгжлийн төв болгоно. Сургууль хүүхдэд мэдлэг, боловсрол, чадвар олгодог төдийгүй эрүүл чийрэг, эерэг зан суртахуун, хүмүүжил, төлөвшилтэй, амьдрах ухаантай, эх оронч, үндэсний бахархалтай хүн болоход нь тусалдаг болно”, “Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад нийгэм, сэтгэл зүй, дэд бүтцийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчин, нийгмийн үйлчилгээг бий болгоно” зэрэг зорилго зорилтууд дэвшүүлсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд байнгын идэвхи, санаачлага, бүтээлч оролцоотой эцэг эх, олон нийт, иргэдийн дуу хоолойг сургуулийн бодлого, чиглэлтэй уялдуулан, тэднийг мэдээллээр ханган, хамтарч ажилласнаар эрүүл бие бялдартай, сурах хүсэл эрмэлзлэлтэй, зөв зан үйлийн эзэн хүүхдийг төлөвшүүлэх нэг талын нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газар, Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Дэлхийн Банкны хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг ТББ-аас манай аймгийн 10 сургуульд туршин хэрэгжүүлсэн “Олон нийтийн

оролцоот сургууль” дэд төслийн хүрээнд буй болсон тэрүүний сайн үйл ажиллагаа, туршлага нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөөц юм.

“Олон нийтийн оролцоот сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өсвөр үеийхнийг өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах чадвартай, бие бялдар, оюун сэтгэхүй, ёс суртахууны төлөвшилтэй хувь хүн болж төлөвшихөд эцэг эх, төрийн үүрэг, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг тодорхойлж, аймгийн бодлогын зорилтыг дэвшүүлэн, хэрэгжилтийг хангах нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах нийтлэг үндэслэл болно.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЧИМ

2.1.Хөтөлбөрийн агуулга, хэрэгжилт нь, орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн уян хатан байна.

2.2.Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих иргэд, гэр бүл олон нийтийн бүтээлч оролцоог эрхэмлэнэ.

2.3.Сургуулийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх тэгш харилцааг дээдэлнэ.

ГУРАВ. ЗОРИЛГО

Сургуулийн орчин дахь орон нутгийн иргэд, эцэг эхчүүдийн бүтээлч, хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоог сайжруулснаар сурагчдын сурлагын амжилт, тэдний хөгжил төлөвшлийг дээшлүүлэхэд ахиц гарган, “ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ СУРГУУЛЬ”-ийг бий болгох

ДӨРӨВ. ЗОРИЛТ

4.1.Ерөнхий боловсролын сургуулиудад байнгын идэвх санаачилга, оролцоотой эцэг эхийн зөвлөлийг бий болгон, тэдний үйл ажиллагааг сургуулийн бодлого чиглэлтэй уялдуулан тогтмолжуулснаар нийт эцэг эхчүүдийн бүтээлч идэвх оролцоог нэмэгдүүлэх

4.2. Ерөнхий боловсролын сургуулиуд “ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ СУРГУУЛЬ”-ийн стандартын чанарын үнэлгээний шалгуурыг хангахад чиглэсэн тогтолцоотой болсноор хүүхэд бүр сэтгэл хангалуун суралцах нөхцлийг бүрдүүлэх

4.3.Сургуулийн үйлчилгээнд иргэдийн хяналтыг буй болгон нийгмийн эгэх хариуцлагыг нэвтрүүлэх.

ТАВ. ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1. Зорилт 1-ийн хүрээнд:

5.1.1.Сургуулийн зөвлөл болон эцэг эхийн зөвлөлийг багш, эцэг эх, сурагчдын оролцоотойгоор байгуулж, ажиллах журам, төлөвлөгөөг жил бүр боловсруулан тэдний үйл ажиллагааг сургуулийн бодлого чиглэлтэй уялдуулан байнгын чадваржуулах нөхцөлийг бүрдүүлэх

5.1.2. Сургуулийн эцэг эхийн зөвлөлийг сургууль, ангид тулгамдаж буй асуудлыг судлан гаргах, шийдэх арга замыг эрэлхийлэн сурагчдын сурлагын амжилт, хөгжил төлөвшлийг дэмжих оролцоо багатай эцэг эхчүүдийг идэвхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

5.1.3. Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан багш эцэг эхийн уулзалт, эцэг эхийн хурлыг чанаржуулах, хэлбэр, агуулгыг сайжруулах загварыг бий болгох

5.1.4. Эцэг эхчүүдийн санал санаачлагаар сайн дурын бүлгэм, клуб, зөвлөлүүдийг байгуулж, чадваржуулснаар эрүүл бие бялдартай, сурах хүсэл эрмэлзэлтэй, зөв зан үйлийн эзэн хүүхдийг төлөвшүүлэх үйл ажиллагаа

5.1.5. Эцэг эхийн зөвлөл, сайн дурын бүлгэм, клубүүдийн үйл ажиллагаагаар дамжуулан сургуулийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, сургалтын чанарыг сайжруулах, санаачилга гаргах, багш, суралцагч, ажилтны эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа

5.2. Зорилт 2-ын хүрээнд:

5.2.1. Сургуулиас үзүүлж буй сургалт болон бусад үйлчилгээний стандартуудын үнэлгээг хийх аргачлалын сургалтыг зохион байгуулах

5.2.2. Сургуулийн хүрээн дэх мэдээллийг нээлттэй, ил тод, эргэх холбоотой болгосноор эцэг эх бусад талуудын сургуулийн үйл ажиллагаанд дахь хяналтыг сайжруулах үйл ажиллагаа

5.2.3. Сургуулиас үзүүлж буй сургалт болон бусад үйлчилгээний чанарыг сайжруулахад эцэг эх, олон нийтийн анхаарлыг хандуулж тэдний дэмжлэгээр сургалтын орчинд өөрчлөлт хийх үйл ажиллагаа

5.2.4. Сум орон нутгийн болон сургуулийн удирдлага, багш, эцэг эхчүүд, сурагчидтай хамтран ажиллах хариуцан тайлагнах хамтын ажиллагаа

5.2.5. Ерөнхий боловсролын сургууль, эцэг эх, бусад байгууллагуудын түншлэлийн тогтолцоог бий болгох үйл ажиллагаа

5.2.6. Сургуулийн удирдлагын манлайллыг хөгжүүлэх, орон нутгийн хүний хөгжлийн төв болгох, сургуулийн соёл, эерэг уур амьсгал, орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа

5.3. Зорилт 3-ын хүрээнд:

5.3.1. Сургуулийн үйлчилгээ, төсөв хуваарилалт зарцуулалтын журмыг танилцуулах сургалтыг сургуулийн зөвлөлийн гишүүдэд зохион байгуулах

5.3.2. Сургуулийн төсвийн төлөвлөлтийн төслийг сургуулийн зөвлөлөөр хэлэлцэх, нийтэд мэдээллэх

5.3.3. Сургуулийн төсвийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Сургуулийн зөвлөл, иргэдэд тайлагнах

5.3.4. Сургуулийн үйлчилгээ, төсвийн төлөвлөлт, зарцуулалтанд хяналт үнэлгээ хийх сургалтыг сум бүрийн иргэдийн төлөөлөлд бүсчлэн зохион байгуулах

5.3.5. Сургуулийн үйлчилгээний чанарт иргэдийн хяналт үнэлгээ хийх арга зүйн зөвлөмж гаргах

5.3.6. Сургуулийн хөгжлийн талаарх бодлогын баримт бичигт шинжилгээ хийх

ЗУРГАА. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

6.1. 2017-2020 онд нийт ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРАХ ҮР ДҮН:

7.1. Сургуулийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо эцэг эхчүүдийн бүтээлч идэвхи нэмэгдсэн байна.

7.2. Ерөнхий боловсролын сургуулиудын бодлогын баримт бичигт олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилт, заалт тусгадаг болсон байна.

7.3. Ерөнхий боловсролын сургууль, эцэг эх, бусад байгууллагуудын түншлэлийн харилцаагаар сургуулийн орчин, үйлчилгээний чанар дээшилж, суралцагчдын сурах сэтгэл ханамж нэмэгдсэн байна.

НАЙМ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

8.1. Аймгийн Засаг даргын Тамгын Газрын Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтийг стратегийн бодлого, төлөвлөлтөөр хангах, хяналт-шинжилгээ хийх үүргийг хүлээнэ.

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг байнгын удирдлага, арга зүй, зохион байгууллалтаар хангах үүргийг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол соёл, урлагийн газар хүлээнэ.

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн, сум орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үүргийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

8.4. Ерөнхий боловсролын сургуулийн захиргаа нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хичээлийн жил бүрийн эхэнд боловсруулан сургуулийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтийг тайлагнан, иргэд болон иргэний нийгмийн төлөөллийн оролцоог хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

8.5. Орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар аймгийн Засаг даргын тамгын газарт жил бүрийн 6 дугаар сарын 20-ны дотор жилд 1 удаа тайлагнана.

8.4.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тайлагнаж байна.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

9.1.Сургуулийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо эгэх хариуцлагын талаарх ойлголттой болсон эцэг эх, олон нийтийн эзлэх хувь

9.2.Сургуулийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж эгэх хариуцлагыг бэхжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, чанар

9.3.Сургуулийн үйлчилгээний чанар, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн оролцоотой хийсэн хяналт үнэлгээ

9.4.Хөтөлбөрийн хүрээнд боловсруулж, түгээсэн гарын авлага, арга зүйн зөвлөмжийн тоо

9.5.Олон нийтийн оролцоо, нийгмийн эгэх хариуцлагын чиглэлээр багш, эцэг эхчүүдэд зориулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо

9.6. ЕБС-иудын үндэсний хэмжээнд нэвтрүүлсэн сайн туршлагын тоо, чанар

---o0o---